



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар A/14


Алтай хот

Аймгийн Соёлын хэлтсийг Соёл,
урлагийн газар болгон өөрчлөн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

- 1.Аймгийн Соёлын хэлтсийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар болгон өөрчлөн байгуулсугай.
- 2.Соёл, урлагийн газрын бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, газрын дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны A/327 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 17 ны өдрийн 11/14 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

Д/д	Албан тушаал	Тоо	Зэрэглэл	Ерөнхий чиг үүрэг
1	Дарга	1	T3-10-5	Төрөөс соёл урлагийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, соёл урлагийн салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж, төсөл хөтөлбөр гадаад дотоодын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг төлөөлөн хэрэгжүүлэх;
Соёл урлагийн хэлтэс				
2	Соёл урлагийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, гадаад харилцаа хариуцсан хэлтсийн дарга	1	T3-7	Соёлын салбарын хөгжлийн стратеги төлөвлөлт хэрэгжилт, хөрөнгө оруулалт, олон улсын гэрээ конвенц, гадаад харилцаа, хамтын ажиллагааг орон нутагт хариуцан, салбарын тайлан мэдээг нэгтгэн гаргах, салбарын хэмжээнд хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, тогтоосон хугацаанд яаманд хүргүүлэх; Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх;
3	Урлаг, уран бүтээл хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг хөгжүүлэх, олон нийтийн урлаг соёл, баяр наадмын арга хэмжээг зохион байгуулах, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих, тэдний эрх ашгийг хамгаалах, түүнтэй холбоотой дүрэм журам тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг хариуцах;
4	Соёл гэгээрэл, соёлын боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Бүх нийтийн соёлын боловсрол, номын сан, соёл гэгээрэлтэй холбоотой хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, аймгийн нийтийн номын сан, сумдын номын санг арга зүйгээр хангах, сэтгүүлч, зохиолчдоос гарсан саналыг дэмжиж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх;

5	Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Соёл урлагийн бүтээлч үйлдвэрлэл, уран зураг, гар урлал, кино контент, ном, уран бүтээлийн үйлдвэрлэл, гадаад дотоодын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн дүрэм журам, тогтоол шийдвэрийг орон нутагт хариуцан хэрэгжүүлэх;
6	Соёлын өв, хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Түүх соёлын үл хөдлөх дурсгал, хөдлөх дурсгал соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын бодлого хэрэгжүүлэн хариуцах;
Захиргааны хэлтэс				
7	Төсөв, санхүү хариуцсан хэлтсийн дарга	1	T3-7	Салбарын төсвийн орлого, зарлагын талаар баримтлах бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах, хяналт тавих, Төсвийн орлогын гүйцэтгэлд судалгаа шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт гаргах; Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх;
8	Мэдээлэл технологи, статистик, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Салбарын статистик мэдээлэл хариуцан тайлагнах, удирдлагыг цаг үеэ олсон үнэн зөв мэдээллээр хангах, мэргэжлийн боловсон хүчний хангалт, сургалт арга зүй, шагнал урамшуулалыг хариуцах;
9	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн	1	T3-5	Салбарын эрхэлсэн асуудал, салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн явц, гүйцэтгэл, хүрсэн түвшинг тодорхойлж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж өгөх, дотоод аудитын хяналт тавих, салбарын хэмжээнд хэрэгжиж буй тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах асуудлыг хариуцах, шашны үйл ажиллагааг дэмжих;
10	Ерөнхий нягтлан бодогч	1	TY-8	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүү, татварын бүх төрлийн тайлан гаргаж удирдлагад болон харилцагч байгууллагуудад хүргүүлж, хугацаанд нь тайлагнах, санхүүгийн бүртгэлийг хууль журам, стандартын дагуу үнэн зөв хөтлөн явуулах, байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих, тооцооны нягтлан, няравын ажлыг санхүүгийн нэгдсэн удирдлагаар ханган,

				хяналт тавьж, зохион байгуулан ажиллах;
11	Архив, бичиг хэрэг, эд хариуцагч	1	ТҮ-5	Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивийн үйл ажиллагааг заавар, стандартын дагуу хөтлөн явуулах, газрын даргын өдөр тутмын ажлын зохион байгуулалтыг хангах; Байгууллагын эд аж ахуй, хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, байгууллагын тохижилтын асуудлыг хариуцна.
Нийт		11		

__оОо__

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 17-ны өдрийн 11/14 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1. Энэхүү дүрмийн зорилго нь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын (цаашид "газар")-ын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын хуульд нийцүүлэн гаргасан бусад захиргааны шийдвэрийг мөрдлөг болгоно.

3. Газар нь зохих хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4. Газрын нэр нь Монголоор "Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар, англи хэлээр "Department of culture and arts of Gobi-Altai province" гэж бичиж хэрэглэнэ.

5. Газрын үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

6. Газар нь бэлэг тэмдэг (лого), тугтай байж болно.

7. Газар нь аймгийн төвд байрлаж үйл ажиллагаагаа явуулах бөгөөд өөрийн өмч, хөрөнгөтэй байна.

Хоёр: Соёл, урлагийн газрын чиг үүрэг

2.1. Газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

2.1.1. Харьяалах нутаг дэвсгэрийнхээ соёл, урлагийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр:

а). Соёлын талаар баримталж буй бодлогыг орон нутгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулах;

б). Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын стратегийн бодлоготой нийцүүлэн аймгийн соёлын стратегийн боловсруулах;

в). Орон нутгийн соёлын онцлог, өв соёлд тулгуурласан аймгийн соёлын бодлогыг төлөвлөх;

2.1.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

а). Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм журмын хэрэгжилтийг хангах;

б). Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан бусад захиргааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

в). Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрт нийцүүлэн хэрэгжилтийг хангах;

2.

2.1.3. Мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах чиглэлээр:

а). Соёл үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

б). Аймгийн Засаг даргад соёл, урлагийн чиглэлээр шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах;

в). Харьяалах нутаг дэвсгэрт соёлын байгууллагыг үүсгэн байгуулах, өөрчлөх асуудлаар Соёлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу саналаа Засаг даргад уламжлах;

г). Аймаг, сумын соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах;

д). Соёлын биет болон биет бус өв хамгаалахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, аймгийн бүртгэл мэдээллийн сан үүсгэх, холбогдох байгууллага, иргэнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

е). Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр аймгийн удирдлага, хуулийн этгээд, иргэнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

ё). Бүх нийтэд соёлын боловсрол олгох, соён гэгээрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагыг удирдлагаар хангах, зөвлөн туслах;

ж). Соёлын ажилтныг гадаад болон дотоодод мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

з). Соёлын ажилтныг олон улс, улс, бүсийн чанартай соёл урлагийн наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, яармагт оролцоход дэмжлэг үзүүлэх;

и). Соёлын ажилтны бүтээлч санаа, шилдэг үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг дэмжих, нийтийн хүртээл болгох;

2.1.4. Бүртгэл мэдээллийн сан, статистик, соёлын үйлчилгээний үр дүн, тайлангийн чиглэлээр:

а). Харьяалах нутаг дэвсгэрийнхээ соёл, урлагийн үйлчилгээ, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх;

б). Харьяалах нутаг дэвсгэрийн соёл, урлагийн байгууллагын статистик мэдээг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цуглуулах, нэгтгэн дүгнэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

в). Хууль тогтоомж, хөтөлбөр арга хэмжээ, холбогдох бусад тайлан мэдээг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнах, мэдээлэх;

Гурав. Эрх, үүрэг

3.1. Газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдан зохион байгуулна. Газрын даргыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж, дэмжсэнээр аймгийн Засаг дарга томилж чөлөөлнө.

3.2. Газар нь үйл ажиллагааны чиглэлээр төрөлжсөн бүтцийн нэгжтэй байна.

3.3. Эрх бүхий байгууллагаас баталсан орон тооны хязгаарт багтаан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажиллагсадтай байна.

3.4. Газар нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох ба зөвлөлийн ажиллах журмыг даргын тушаалаар батална.

3.5.1. Газрын дарга нь дараах бүрэн эрхтэй:

а). Дарга нь хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дарга, төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана;

3.

б).Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

в).Газрын дунд, богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж хэрэгжилтийг хангах;

г).Газрын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам зааврыг батлах

д).Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдийг томилж, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

е).Газрын ажилтнуудын ажлыг төлөвлөх, дүгнэх, нийгмийн баталгааг хангах;

ё).Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, удирдах, гүйцэтгэлийг хангах,

ж).Соёлын ажилтанг шагнаж урамшуулах төр, засгийн шагналд тодорхойлох;

з).Гадаад болон дотоодын ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлцэл хийх тохиолдолд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл авах;

и).Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх;

Дөрөв. Бусад

4.1.Соёл, урлагийн газар нь улсын болон орон нутгийн төсөв, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

4.2.Төсвийн тухай хуулинд заасан хугацаанд санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

4.3.Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар, улирал, жилийн өссөн дүнгээр гарган холбогдох дээд шатны байгууллага болон Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.4.Газрын үйл ажиллагаатай холбоотой энэ дүрмээр зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.